

Оюу толгой ХХК-ийн Уул, уурхайн ажилтны ҮЭХорооны 2-р улирлын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан

2022 оны 06 дүгээр сарын 30

Хамрах хугацаа: 2022.04.01-2022.06.30



Агуулга

- Цалин хөлс, илүү цагтай холбоотой хэлэлцээрийн тайлан
- 2022 оны 2-р улирлын үйл ажиллагааны тайлан
- 2022 оны 2-р улирлын тогтоол, явсан бичиг, ирсэн бичиг
- Шинээр элссэн гишүүдийн тоо
- 2022 оны 2-р улирлын Санхүүгийн тайлан
- Өргөдөл, гомдлын тайлан

- Цалин хөлс, илүү цагтай холбоотой хэлэлцээрийн тайлан

ОТ ХХК болон ҮЭХ хооронд 2022 оны 03 дугаар сарын 14-нд эхлүүлсэн цалин хөлстэй холбоотой хэлэлцээр 04 дүгээр сарын 22-нд өндөрлөлөө.

ҮЭХорооны зүгээс санаачилж Оюу толгой ХХК-д үндсэн цалингийн нэмэгдэл болон илүү цагийн хөлсийг тооцуулахтай холбоотой хэлэлцээрийг эхлүүлсэн билээ.



Тэргүүлэгч гишүүд болон хэлэлцээрийн бүрэлдэхүүн нь нийт 8 удаагийн уулзалтыг хийж, хууль тогтоомж, эдийн засгийн нөхцөл байдлийг үндэслэн дараах нэмэлт өөрчлөлтүүдийг хэлэлцээрийн үр дүнд оруулж чадлаа. Үүнд:

1.




2.




3.




4.






5.



6.



7.



7.



УЛС ОРОН, ХАМТ ОЛНОО ТӨЛӨӨЛӨХ ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ

ХАМТЫН ГЭРЭЭНД ШИНЭЭР ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТ

5 ХҮРТЭЛХ ӨДРИЙН ОЛГОВОРТОЙ ЧӨЛӨӨ

ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ СПОРТЫН ТЭМЦЭЭНД ОРОЛЦОЖ БУЙ АЖИЛТАНД

3 ХҮРТЭЛХ ӨДРИЙН ОЛГОВОРТОЙ ЧӨЛӨӨ

САЛБАРЫН ТЭМЦЭЭНД ОРОЛЦОЖ БУЙ АЖИЛТАНД

9.



ХАМТЫН ГЭРЭЭНД ШИНЭЭР ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД

ХАМТЫН ГЭРЭЭНД ШИНЭЭР ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТ

**ДУНДЖААР 25 БОЛОН ТҮҮНЭЭС ДЭЭШ ХУВИАР ЦАЛИН
ХӨЛС НЬ БУУРСАН АЖИЛТНУУДЫН НӨЛӨӨЛЛИЙГ
НЯГТЛАН ҮЗЭЖ, НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ**

ШИНЭЧЛЭН НАЙРУУЛСАН ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХҮУЛИЙН ХҮРЭЭНД

8.



ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ УЛМААС ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ ЦУЦЛАХ

3 САР

ЦАЛИНТАЙ ТЭНЦЭХ ТЭТГЭМЖ
(ӨМНӨХ ХАМТЫН ГЭРЭЭГЭЭР)

1-4 САР

ҮНДСЭН ЦАЛИНТАЙ ТЭНЦЭХ ТЭТГЭМЖ
(ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХҮУЛИЙН ДАГУУ)



12 САР

ҮНДСЭН ЦАЛИНТАЙ
ТЭНЦЭХ ТЭТГЭМЖ
(ШИНЭЧЛЭГДСЭН ХАМТЫН ГЭРЭЭГЭЭР)

10.



НИЙТЭЭР АМРАХ БАЯРЫН ӨДРИЙН НЭМЭГДЭЛ

ХАМТЫН ГЭРЭЭНД ШИНЭЭР ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТ

**УРТЫН ЭЭЛЖИЙН АЖИЛТАН НИЙТЭЭР АМРАХ
БАЯРЫН ӨДӨР АЖИЛЛАСАН ТОХИОЛДОЛД ҮНДСЭН
ЦАЛИНГ 2 ДАХИН НЭМЭГДҮҮЛСЭНТЭЙ ТЭНЦЭХ
ҮНЭЛГЭЭГЭЭР ТООЦОЖ 2022 ОНЫ 6 ДУГААР САРЫН
1-НИЙ ӨДРӨӨС ЭХЛЭН ОЛГОНО**

7.



8.




9.



10.




11.



12.



13.



- 2022 оны 2-р улирлын үйл ажиллагааны тайлан

- Олон улсын “Хөдөлмөрчдийн эв санааны нэгдлийн өдөр”-ийг тохиолдуулан 05 дугаар сарын 01-ний 10:30 аас 13:30 цагийн хооронд МҮЭ-ийн холбоо нэгдсэн зохион байгуулалттай жагсаалыг Сүхбаатарын талбай дээр зохион байгуулсан ба бидний зүгээс Илүү цагийг тооцон олгох, Монгол Улсын Дээд шүүхийн тайлбар гаргахыг шаардан жагассан билээ.



2. Уртын ээлжээр ажилладаг ажилтнуудад илүү цагийн хөлс олгуулах асуудлаар МЭХГУУҮЭХ-той хамтран хэвлэлийн бага хурлыг 2022 оны 5 сарын 02-ны өдөр хийв

3. Уртын ээлжээр ажилладаг ажилтнуудад илүү цагийн хөлс олгуулах асуудлаар ХЗДХ-ийн сайд Х.Нямбаатар, Төрийн нарийн бичгийн дарга С.Ганзориг нартай уулзалт хийв.

4. УУХҮ-ийн сайд Г.Ёндон-той уулзалт хийх хүсэлт гаргаж, холбогдох газрын дарга, мэргэжилтнүүдэд асуудлыг танилцуулав.

Дээрх уулзалтуудын үр дүнд ХЗДХЯ болон УУХҮЯ-ны зүгээс холбогдох төрийн захиргааны төв байгууллага буюу ХНХЯ-нд асуудлыг нааштайгаар шийдвэрлэх тал дээр анхаарч ажиллахыг уламжлахаа мэдэгдэв.




5. Хэвлэл мэдээллийн хүрээнд доорх хандалт өндөр гэсэн мэдээллийн хэрэгслэлээр цахим нөлөөллийг хийлээ. Үүнд:

- Уул уурхайн ажиллагсад энэ оноос 14, 14 ээлжээр ажиллаж байгаа. Хуулийн энэ өөрчлөлтөөр ажиллагсдын цалин 40-50 хувиар буурч, аж ахуй нэгжүүд нэмэгдэл хөлс өгөхгүй байгааг өөрчлөх шаардлагатай талаар МЭХГУУ ҮЭХолбооны дарга Д.Долгорийг НТВ болон eagle tv ярилцлагуудад оруулав.




- Мөн тус асуудлаар zarig.mn, news.mn, ikon.mn-д ярилцлага өгүүлэв



6. ҮЭХорооны ажлын алба 2022 оны 05 сарын 23-25 өдрүүдэд Уурхайн талбар дээр очин ажиллаа

Тус өдрүүдэд ҮЭХ-ны ажлын алба нь :

- 2022-2025 онд үйлчлэх хамтын гэрээнд орсон өөрчлөлтийн талаарх бичлэгийг гишүүддээ Баяжуулах үйлдвэр, Ил уурхайн 2 ээлж, админ оффисын ИТ, Далд уурхайн хяналтын өрөөнд ПРЕСТАРТ-ын үеэр үзүүлж асуултанд хариулав.
- 2022.05.24: Админ оффисын ИТ хэсгийхэнд, Ил уурхайн шөнийн ээлжийн 2 багийханд тус тус танилцуулав. Уулзалт тус бүр 1 цаг орчим үргэлжилсэн.





- 2022.05.25: Баяжуулах үйлдвэрийн засварын хэсгийн өглөөний ээлжинд танилцуулав. Далд уурхайн хяналтын өрөөнийн үйл ажиллагаатай танилцав. Хоолны хорооны хуралд оролцов.
- Гишүүд ажилчдаас шаардлагатай санал, хүсэлт, гомдол мэдээллийг хүлээн авав.
- Хоолны хорооны 2 дахь хурлыг төлөвлөн хийв

Гэх зэрэг ажлуудыг томилолтын хугацаандаа ҮЭХ-ны ажлын албан хийж гүйцэтгэсэн ба ажилчдын болон гишүүдийнхээ ажиллаж байгаа нөхцөл байдалтай танилцаад ирлээ. Бид цааш цаашдаа гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалан сайжруулалт дээр анхааран ажиллах болно.



7. 2022 оны 05.13 болон 05.17 өдрүүдэд messagepro үйлчилгээг ашиглан ҮЭХ-ны 2417 гишүүдийн утас руу message явуулан “Эрүүл мэндийн даатгалын” болон “Мазаалай хоолны газрын, Боолтын хоолны амт чанарын” судалгааг авсан ба Эрүүл мэндийн даатгалын судалгаанд нийт 596 хүн, “Мазаалай хоолны газрын, Боолтын хоолны амт чанарын” судалгаанд нийт 1,229 хүн тус тус хамрагдсан байна.



2022 оны Тогтоол, Ирсэн бичиг, Явсан бичиг /04.01-06.30-ний байдлаар/

- **Тэргүүлэгчдийн тогтоол -12**

- Үйл ажиллагааны зардал батлах тухай -7
- Гэрээт нягтлан бодогч ажиллуулах тухай-1
- Эрх олгох тухай-1
- Комиссын гишүүд томилох тухай-2
- Дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай-1

- **Явсан бичиг – 18**

- МЭХГУУҮЭХолбоо -2
- Оюу толгой ХХК -9
- ХЗДХ Сайд Х.Нямбаатар-1
- Датаком ХХК-1
- УИХ гишүүн Н.Наранбаатар-1
- УИХ гишүүн Д.Бат-Эрдэнэ-1
- УУХҮ Сайд Г.Ёндон-1
- Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх-1
- Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн 2-р хэлтэс-1

- **Ирсэн бичиг- 15**

- Улсын бүртгэлийн ерөнхий газар-1
- Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх-1
- Оюу толгой ХХК-7
- Зэсийн группийн гүйцэтгэх захирал Б.Болд-1
- Чингэлтэй дүүргийн НД хэлтэс-1
- Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн 2-р хэлтэс-1
- МЭХГУУҮЭХолбооны Хяналтын хороо-1
- ХЗДХЯ-2
- ҮЭХ-ны Хяналтын хороо-2

Шинэ гишүүдийн тоо /06.30-ний байдлаар/.....гишүүнтэй байна

Тэргүүлэгчийн нэр	Шинээр элсүүлсэн гишүүний тоо	/04.1-06.30/
Н.Эрдэнэбаяр	7	
Ц.Очирбат	4	
Б.Наранбаяр		
Э.Хатанбаатар		
Д.Золжаргал	6	
Т.Оюун-Эрдэнэ	2	
Р.Бадрал	7	
П.Гэрэлмандах	6	
Г.Ууганбаямба	20	
Д.Чулуунбаяр	6	
Г.Идэр	21	
М.Энхтайван	7	
Г.Билгүүдэй	8	
А.Үнэнбат		
П.Өнөболд	19	
Т.Тэнгэс	22	
Нийт	166	

Бусад хийгдсэн ажил

- Тэргүүлэгчид өөрсдийн тойргийн гишүүдэд танилцуулга уулзалтуудыг уурхайн талбарт зохион байгуулав
- Долоо хоног 1 дэх өдөр болгон Тэргүүлэгчдийн хурлыг Zoom ашиглан хийж, record-ийг хадгалж байна.
- Тэргүүлэгчдийн хурал-9 удаа, Оюу толгой ХХК-тай 5 удаа уулзалт хийсэн
- ҮЭХорооны мэдээллийг хадгалах, хоорондоо хуваалцах зорилготой shared folder-ийг G suite дээр нээн ашиглаж эхлэх гэж байна
- ҮЭХорооны мэдээллийг түгээх зорилгоор www.OTTU.mn цахим хаягийг мэдээ мэдээллийг цах алдалгүй оруулан ажиллуулж байна.

ОТУУАҮЭХорооны 2022 оны 2-р улирлын зардал

№	Зардлын бүлэг	Үнийн дүн
2	Цалин хөлс/дарга, менежер, нягтлан/	23,036,447
3	Оффис түрээс	9,600,000
4	Сургалт, зөвлөх үйлчилгээ	700,000
5	Спортын наадмын спонсор	12,045,000
6	Өр төлбөр /нийгмийн даатгал, тэмдэгтийн хураамж/	13,250,967
7	Эд хогшил/кофе машин, гадаа хаяг/	4,299,900
8	Бичиг хэрэг /оффис хэрэглээ/	300,000
9	МҮЭХолбооны гишүүнчлэлийн татвар	9,000,000
10	Харилцаа, холбоо /и-мэйл, утас, мессеж про/	1,394,950
11	Онлайн үйлчилгээ /docu sign, вэбсайт/	3,361,000
12	Хэвлэл мэдээлэл, PR	11,468,960
13	Банкны шимтгэл	11,300
	Нийт зардал	88,468,524

2022 оны Өргөдөл, гомдлууд /06.30-ний байдлаар /

- 2022 оны 0.4.01-06.30 өдрийн хооронд ирсэн
- Өргөдөл, гомдол 5
- Оюу толгой ХХК-д танилцуулсан 5
- Оюу толгой ХХК-д танилцуулаагүй 0
- Хариуг ажилтанд өгсөн 1
- Хариу хүлээгдэж буй 4